

СОЁЛ

АРДЫН ДОМОГ ТҮҮХИЙГ ӨГҮҮЛНЭ**М. Зэнээ**

Монголын ард түмний дунд ихээхэн дэлгэрсэн аман зохиолын нэг төрөл бол домог юм. Ардын домгийн бүр эртний хэлбэр нь домог үлгэр юм. «Домог үлгэрийн зүйл нь үлгэрийн төрлөөс эрс тэс ялган зааглахад нэлээд төвөгтэй»¹ байдаг гэж манай аман зохиол судлаачид тэмдэглэсэн байдаг. Учир нь домог-үлгэр бол хүн төрөлхтөн байгалийн элдэв үзэгдлийн өлөн чанарыг тайлбарлах түүнийг өөрсдийн сайн сайхны тулд ашиглах гэсэн мөрөөдөлтэй зарим талаар холбоотой байсан учир үлгэртэй нэлээд төстэй байдаг. Харин ардын домог бол ард түмний түүх, тухайн нийгмийн хөгжлийн түүхтэй холбоотой учир ангийн тэмцлийг ихэвчлэн тусгасан байдаг. Эртний домог-үлгэрийн уламжлалд тулгуурлан хөгжсөн ардын түүхэн домог нь тухайн нийгмийн үзэл санаа, ард түмний түүх, ангийн тэмцлийн мөн чанарыг олон талаас нь тусган харуулсан байдаг тул түүх аман зохиолын судалгаанд чухал байр эзэлнэ. Монголын ард түмний дунд яригдах олон тооны ардын домог нь домог үлгэрийн зүйлээс ялгаатай, нийгмийн хөгжлийн түүхтэй ямар нэг талаараа заавал холбоотой байдаг. Энэ өгүүлэлд бид монголын ард түмний өвөг дээдэс эх орныхоо эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө, харийн дарлал боолчлолоос ангижрахын тулд хэрхэн тэмцэж ирсэн бодит үнэнийг ардын домогт хэрхэн яаж тусгасныг товч хөндөхийг зорилго болгов. Монголчуудын дунд дэлгэрсэн ардын домог бол монголын ард түмний бүтээн тууриг авсан ардын уран бүтээл юм. Энэ уран бүтээлийг судалж, түүнийг мэдэж, залуу үед ойлгуулах нь тухайн үеийн хөдөлмөрчин ард түмний тэмцлийн түүхийг ойлгоход ихээхэн ач холбогдолтой билээ. Пролетарийн их зохиолч М. Горький Зөвлөлтийн зохиолчдын нэгдүгээр их хурал дээр: «Ардын уран бүтээлийг мэдэхгүйгээр хөдөлмөрчин ард түмний түүхийг мэдэж болохгүй»² гэж хэлсэн байдаг. Монголын ард түмний түүхийг ойлгоход ардын домгийг зохих хэмжээгээр судлах нь зайлшгүй шаардагдах зүйл мөн. Монголын ард түмэн харийн булаан злэгчдээс эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалан тэмцэж явсан эх оронч хөвгүүдээрээ бахархаж, тэдний үйл амьдралын баатарлаг жишээгээр залгамж үеэ хүмүүжүүлэхийн тулд бодит түүхэнд тулгуурлан зохиосон олон сайхан ардын домгуудыг эрт цагас хүүрнэн хэлэлцсээр иржээ. Домог бол зүгээр нэг зохиомол үг биш учраас болсон хэрэг ба бодит үйл явдлын ул мөрийг ямар нэг хэмжээгээр заавал хадгалан үлдсэн байдаг гэж аман зохиол судлах марксист шинжлэх ухаан тодорхойл-

¹ «Монгол ардын үлгэр» УБ. 1982. 17-р тал.

² М. Горький. О. литературе. М. 1955. стр. 738

дог билээ. Иймээс ардын домог бол тухайн үеийн нийгмийн үзэл санаа, түүхт үнэн явдлыг судлахад онцгой ач холбогдолтой³ байдаг.

Монголд дэлгэрсэн домог, түүхэн үлгэрүүд бол маш эртний үеэс эхлэн одоо манай үеийг хүртэл уламжилж ирсэн, олон зуун жилийн түүхэнд болж өнгөрсөн үнэн үйл явдал ба түүхэнд товойсон хүмүүсийн нэртэй холбогдсон байдаг⁴ гэж зөвлөлтийн монголч эрдэмтэн, академич Б. Я. Владимирцов олон жилийнхээ судалгаанаас үндэслэн дүгнэсэн байдаг. Монголын ард түмний дунд түгээмэл тархсан ардын домгийн ихэнх нь манж, хятадын дарлалын эсрэг чиглэлтэй байдаг нь жирийн хэрэг биш. Яагаад гэвэл сүүлийн 300 гаруй жилийн түүхэнд монголын ард түмний гол дайсан нь манжийн булаан эзлэгчид, хятадын мөнгө хүүлэгч, худалдаачид, цэргийн эрхтнүүд байсан билээ. Тэдний эсрэг монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө баатарлагаар тэмцэж явсан томоохон төлөөлөгчдийн тоонд Амарсанаа, Чингүнжав нар зүй ёсоор ордог юм. Иймээс тэдний тухай домог монголын ард түмний дотор олон хувилбараар тархан түгсэн байдаг. Цэрэг феодалын Манж Чин гүрэн нийт монголын эсрэг олон үе шаттай (тухайлбал тодорхой 3 үе шаттай) түрэмгийлэл үйлдэж, эрхшээл нөлөөгөө улам улам хүчтэй болгохыг оролдож байсан үеэс эхлэн Монгол даяар төрийн тусгаар тогтнолоо хамгаалахын төлөө манжийн колоничлогчдын эсрэг зориг баатарлаг тэмцэл хийсээр байсны зэрэгцээ манжийн колончлогчдын далавчин дор Монголын эд баялагт шунасан хятадын мөнгө хүүлэгч, худалдаачдын мөлжлөгийг эсэргүүцсэн тэмцэл нэгэн зэрэг өрнөсөөр байв. Уул тэмцлийг Баруун Монголд Амарсанаа Ар Монголд Чингүнжав, Өвөр Монголд Сэвдэнбалжир нарын зэрэг манжийн эсрэг, эх оронч үзэл бодол агуулсан зарим ноёд толгойлсон⁵ билээ. Эдгээр бослого хөдөлгөөн урт хугацаанд тэсвэр хатуужилтай үргэлжилсэн боловч манжийн дарангуйлагч хаадын зальхай бодлого, монголын феодалуудын хоорондын зөрчил, тэмцэл болон зарим феодалуудын урвалт зэрэг хэд хэдэн шалтгааны улмаас дарагдсан түүхтэй. Нийт Монголын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцлийн хөдөлгөгч хүч болж байсан жирийн малчин ардууд харь манжийн колончлолын талхинаас улс орноо чөлөөлөхийн тулд хийж байсан эрх чөлөөний баатарлаг тэмцлийн түүхийг үр удамдаа ам дамжуулан ярьж уламжлуулан үлдээсэн нь цаашид баяжин хөгжсөөр ардын домог болон тархсан нь олонтой. Ард түмний дунд тархсан ийм домог дараагийн үеэ эх оронч, эрх чөлөөнд дуртай хүмүүс болгон хүмүүжүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлдэг байсан нь олон баримтаас тодорхой байдаг.

Манжийн ноёрхолд орохын эсрэг үндэснийхээ тусгаар тогтнолыг цусаараа хамгаалан шийдвэртэй тэмцэж явсан Амарсанаа, Чингүнжав нар хэдийгээр амь үрэгдсэн боловч тэдний нэр төр, алдар гавьяа, тэмцлийн баатарлаг дүр нь ард түмний санаа сэтгэлээс өнөө хүртэл салж мартагдаагүй, үүрд дурсагдан дуулагдсаар ирсэн байна. Монголын ард түмэн тэднийг харь манжийн харгис ноёрхлын эсрэг зүрх зоригтой тэмцэж явсан эрэлхэг баатрууд гэж магтан дуулахдаа Амарсанаа, Чингүнжав нар асар удахгүй дахин гарч ирээд манжийн дарлалыг түлхэн унагааж, ард түмнээ авран жаргаана хэмээн мөрөөдөн зөгнөсөн байдаг. Б. Я. Владимирцов «Ямар нэг нэрд гарсан бодит хүний тухай ардын үлгэр домог нь саяхны болж өнгөрсөн үетэй холбогдон тэр үеийн үйл явдлыг харуулдаг боловч түүхэн үнэнээс хазайх нь нэ-

³П. Хорлоо. Монгол ардын явган үлгэр. УБ. 1960. 89-р тал.

⁴Б. Я. Владимирцов. Монгольские сказания об Амурсане», «Восточные записки» Т. I. Л. 1927. стр 271

⁵«Дорнодахины судлалын асуудал» сэтгүүл. УБ. 1982. № 2 (7) 53-р тал.

лээд олонтой байдаг. Тэглээ ч гэсэн иймэрхүү үлгэр домгийг цуглуулж судлах нь чухал бөгөөд сонирхолтой байдаг. Учир нь тэдгээрт ард түмний гайхамшигт бодол санааг илэрхийлж тэдний хүсэл эрмэлзлэлийг харуулдаг юм»⁶ гэсэн нь дээр өгүүлсэн Амарсанаа, Чингүнжав нарын домгийн түүхэн үнэнээс хазайсан зарим зүйлийг хөндөсний зэрэгцээ түүнийг цуглуулж судлах нь монголын ард түмний манжийн дарлалаас чөлөөлөгдөх гэсэн санаа сэтгэлийн нийтлэг эрмэлзлийг мэдэхэд чухал ач холбогдолтойг өгүүлжээ.

Бослогын нэрт удирдагч Амарсанаа 1757 оны 8-р сарын 15-нд дайсны илт давуу хүчийг олон удаа цохисон боловч хүч хүрэхээ болиод арга буюу Оросын хилийг давж 1757 оны 9-р сарын 21-ний өдөр салхин цэцэг өвчний улмаас нас баржээ.⁷ Ялангуяа Амарсанаагийн Орост гарсан тухай ардын аман зохиолд үлдсэн нь их бөгөөд түүнийг чухам Оросын зүгээс ирж ард түмнээ авран жаргаана хэмээн ардын домогт олонтаа өгүүлсэн байдаг.

Ийм итгэл нь олны хүслийг эзэмдэж манж, хятадын эсрэг тэмцэх тэмцэлд ард олон нэгдэхийг нийтэд уриалсан уриа болж байжээ. 1890 оны үеэр Оросын эрдэмтэн А. М. Позднеевийг Монгол нутагт явахад удалгүй Амарсанаагийн хувилгаан тодорч манжийн талхидлыг түлхэн унагаана гэсэн цуу чимээ энд тэндгүй дуулдаж байсан⁸ гэдэг.

Тэрчлэн орос, зөвлөлтийн нэрт эрдэмтэн Б. Я. Владимирцов 1908 онд Монголын баруун хязгаараар явахдаа Амарсанаагийн домог ихэд дэлгэрснийг онцлон тэмдэглэж байв. Тэд «Бүгдээрээ л Амарсанааг ойртон ирж яваа тухай шууд мэдээ авсан юм шиг хүлээж байна»⁹ гэж тэмдэглэсэн байдаг. Б. Я. Владимирцовыг Ховдын хязгаарт явахад нэг дөрвөд залуу очиж уулзаад Амарсанаагийн тухай сураглан асуужээ. Тэр залуугийн бодлоор бол Амарсанаа Орост батгаа бөгөөд хэзээ мөдгүй Монголдоо хүрэлцэн ирэх болоод байгаа юмсанжээ¹⁰ гэж тэмдэглэсэн байна. Одоо ч гэсэн Ховд, Увсаар явахад ард түмний аман ярианд Амарсанаагийн тухай домог маш элбэг дайралдах бөгөөд нутгийн уртын дуунд Амарсанааг магтан дуулсан дууны үг цөөнгүй байна. Тэр ч байтугай Амарсанаагийн тэмцлийн түүхийг бүтэн гурван цаг ярьдаг настай хүн 1982 онд Ховдын Эрдэнэбүрэн, Увсын Ховд суманд байсан билээ. Үүнийг үргэлжүүлэн судлууштай юм.

Үүнээс үзвэл монголын ард түмний өвөг дээдэс залуу үеэ эх орныхоо эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө баатарлаг тэмцэгчид болгон хүмүүжүүлэхэд хичнээн их анхаарал хандуулдаг байсны баримт мөн.

1755—1758 оны тусгаар тогтнолын төлөө тэмцлийн удирдагч Чингүнжав 1757 оны 3-р сарын 11-нд Бээжинд цаазаар авахуулсан бөгөөд түүний бие дээр улайтгасан 81 зоос тавьж, зоосны нүхээр цухуйсан мах бүрийг огтолж, дараа нь амьдаар өвчүүг нь хадаад, хамгийн сүүлд толгойг нь тас цавчин хаясан¹¹ хэмээн ардын ихэнх домогт өгүүлдэг билээ.

Монголын ард түмэн эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэгчдийг ардын домогт тусгахдаа тэдний эх оронч үзэл санаа хэзээ ч ялагдашгүй. Тэд хэдийгээр амь үрэгдсэн ч харийн булаан эзлэгчдийн эсрэг

⁶П. Хорлоо. Монгол ардын явган үлгэр. УБ. 1960, 89-р тал.

⁷Н. Ишжамц. Монголын ард түмний 1755—1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл. УБ. 1962. 81-р тал.

⁸А. М. Позднеев. Монголия и Монголы. Т. I. СПб 1896. 45—46-р тал

⁹И. Я. Златкин. Русские архивные материалы об Амурсане. 289-р тал

¹⁰Мөн тэнд

¹¹Г. Н. Потанин. Очерки Северозападной Монголии. Вып II СПб. 1881 с. 305—307

тэмцээр байсан мэтээр харуулсан нь эрх чөлөө, тусгаар тогтнолыг нүдний цөцгий мэт хайрлаж явах ёстой гэсэн гүнзгий утга санааг агуулжээ. Тухайлбал Чингүнжавын тухай домогт түүхийг цаазаар авахуулсны дараа манжийн хааны хатаны бие шалтгаантай болж хүүхэд төрүүлсэн нь биеэрээ дүүрэн цоохор хүүхэд гарчээ. Мэргэд зурхайч нараар үзүүлсэнд түүнийг Шадар вангийн сүнс байна. Зоосны нүхээр тарчилгасны ор мөр гарчээ гэж айлдсан гэдэг. Манжийн хаан ихэд эмээж нөгөө хүүхдээ алуулжээ. Гэтэл тун удалгүй хатан дахин хөл хүндэрч бас нэг хүүхэд төрүүлсэн нь хүзүү нь тасархай юм шиг улаан оромтой байжээ. Мөн л мэргэд зурхайчаар үзүүлбэл Шадар вангийн толгойгоо цавчуулж үхсэний сүнс гэжээ. Хаан улам их айж тэр хүүхдийг галд шатаалган алаад үнсийг нь нунтаглан нүдүүлж усанд цацжээ гэж гардаг. Энэ бол дээр өгүүлснийг батлаад зогсохгүй эх орны эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө нэг хоёр баатар төдий бус, нийт ард түмэн тэмцэх ёстой гэсэн санаа агуулжээ.

Монголын ард түмний 1755—1758 оны тусгаар тогтнолын тэмцлийн удирдагч Амарсанаа, Чингүнжав нар Монгол эх орныхоо ихээхэн хэсгийг манжийн эзлэлтээс чөлөөлөөд тусгаар тогтносон Монгол улсынхаа төрийг хэвээр сэргээн хадгалах зорилготой байжээ. Энэ бол Монголын ард түмний 1755—1758 оны туршид тасралтгүй явуулсан зэвсэгт их тэмцлийн гол зорилго, үндсэн чиглэл мөн байлаа.¹² Гэвч цэргийн тоо, зэр зэвсгийн хувьд давуу хүчтэй дайсан ялагдах бүр улам олон цэрэг хойно хойноос нь нэмэн илгээх замаар тусгаар тогтнолын төлөө тэмцэгчдийг цохиж, энгийн номхон ард иргэдийг толгой дараалан хүйс тэмтэрч хядсаар монголын газар орныг эзлэн авсан билээ.

Монголын тусгаар тогтнолын сүүлчийн гал голомт болж байсан Монголын баруун жигүүр буюу Баруун Монголын ард түмэн манж нарт бууж өгөөгүй, эх орны тусгаар тогтнолын төлөө эрэлхэг тэмцлийг 60 гаруй жил хийж, ихээхэн хохирол сүйрэлд учирсан билээ. Тэр үеийн манж хааны нэгэн зарлигт дурдсан нь: «Өөлдийн зүүн гарын иргэн нь маш бусар бөгөөд дагах төлөв огт үгүй, үргэлж их санаа агуулан тэмцэх тул 13—60 нас хүртлэх эрчүүдийг хүйс тэмтэрвэл олонд зовлон тохиолдохгүй болно»¹³ гэжээ. Зарлигийн дагуу Баруун монголын хүн амыг эр эм, нялхас өтгөс ялгаагүй бүгдийг уул ус, ой хөвч хээр тал, цөл говь хаана ч адил зэрлэг араатан намнах адил эрэн хайж хядан устгаж байжээ.¹⁴ Ийнхүү монголын ард түмэн харь манжийн колончлолд орсон боловч манжийн түрэмгийлэгчид, хятадын мөнгө хүүлэгч, худалдаачдын эсрэг тэмцлээ нэгээхэн ч удаа зогсоож байсангүй. Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө олон үеийн баатарлаг тэмцэл Октябрийн аугаа их хувьсгалын шууд нөлөөгөөр 1921 онд ялсан Монголын Ардын Хувьсгалын ялалтаар түүхэнд анх удаа амьдралд биелэгдэж, манай ард түмэн гадаад, дотоодын дарлал, мөлжлөг» түрэмгий өнгөлзлөгөөс эх орон, эрх чөлөө, тусгаар тогтнолоо найдвартай хамгаалсаар ирлээ. Гэвч орчин үед олон улсын байдал ноцтой хурцдаж, нарийн төвөгтэй ээдрээтэй болох явдал ихээхэн газар авч байна. Олон улсын харилцаанд гарч байгаа таатай биш нөхцөлийг улам хурцатгаж байгаа гол хүч бол империалист харгисууд, юуны өмнө Америкийн империализм, тэдний гар хөл, холбоотон болох их гүрний дээрэнгүй жанжлагчид болохыг мартаж болохгүй. Ийм үед улс хоорондын харилцааны урьд өмнөх түүх, ялангуяа Манж болоод хятадын төрөөс монголын хувьд явуулж ирсэн түүхэн уламжлалт бодлогыг

¹² Н. Ишжамц дурдсан зохиол. УБ. 1962

¹³ Мөн тэнд

¹⁴ «Дорнодахины судлалын асуудал» сэтгүүл. 1982. № 2. (7) 54-р тал

гүнзгий судлан үзэж, түүний эсрэг монголчуудын хийсэн баатарлаг тэмцэл, уг тэмцэлтэй холбоотой ардын домгийг судлан залуу үед түүхийн үндэстэй ойлгуулах нь тэдний эх оронч үзэл бүрэлдэн тогтоход чухал ач холбогдолтой юм. Манжийн төрийн колоничлох бодлогыг эсэргүүцсэн монголын ард түмний тэмцлийн өөр нэг сонин хэлбэр нь сайн эрсийн тэмцэл байв. Сайн эрсүүд голдуу хоёр нэгээр нийлж, хятадын мөлжимтгий худалдаачдын бүгшиж байсан тосгон сууринг уулгалан дайрах буюу хар шар феодалуудын мал хөрөнгийг хэдэн хошуу аймаг дамжуулан хөөж эсэргүүцлээ илэрхийлдэг байсан бөгөөд гадаад дотоодын давхар дарлалаас болж амьдралын хувьд туйлын хүнд болсон ядуу ардуудад булаан авсан зүйлээ тараан өгдөг байжээ. Иймээс ард түмэн тэднийг хулгай хийдэг муу хүмүүстэй жишин үзэх нь ховор бөгөөд харин өөрсдийн төлөө тэмцэгч баатар эрсийн ёсоор үзэж, тэдний тухай үлгэр домог зохиосон нь элбэг үзэгдэнэ.

Гэвч зарим үед ашиг хонжоонд дуртай «жигжиг тугалын бэлчээрээс цааш яваагүй, жирэмсэн эмийн шээх газраас холдож үзээгүй» гэгдэх хүмүүс «сайн эр» нэр зээлдэн хаяа хатгасан айл хөршийнхөө амь зуулгын ганц хоёр морь тэмээг хулгайлдаг явдал ч гарч байжээ. Ийм хүмүүсийг ард түмэн «муу хулгай», «хаяагаа хадрагч» «муу эрс» хэмээн гэдэг байв.

Дарлагч ангийн эсрэг тэмцлийн өвөрмөц, ашиг багатай, ганцаардмал хэлбэр сонгон авсан «сайн эрс» хэмээх хүмүүс «хаяагаа хадрахгүй, хавьтсанаа авахгүй», ялангуяа өөрийн ард түмнээс бол «сэтэрхий тэвнэ, сэмэрхий хадаг ч хулгайлахгүй» гэсэн андгайтай байжээ. «Сайн эрс» гэдэг бол зөвхөн хулгай хийдэг хүмүүс л байсан мэтээр ойлгох явдал нэлээд байдаг бөгөөд энэ нь ташаа зүйл гэдгийг юуны өмнө тэмдэглэмээр байна. Тэд нийгмийн хүнд хэцүү дарлалаас болж нүүдэлчин ард түмний онцлогт тохирсон ангийн тэмцлийн өвөрмөц нэгэн хэлбэрийг сонгосон хүмүүс байсны зэрэгцээ, харийн дарлалын эсрэг шийдвэртэй тэмцэгч хувь хүмүүс байжээ. Манжийн дарлалын үед ийнхүү сайн эрс гэдэг нэрээр монголчууд тэмцлээ явуулж байсан боловч тэд цөөн бүлгээрээ тэмцэх тул нийт олныг хамарч чадахгүй байсны зэрэгцээ тэмцэл нь голдуу хувийн өшөө хорсол, гомдол бухимдлаа тайлах шинж чанартай байсан тул далайц, нөлөө багатай байжээ. Ийм тэмцэл нь нийт монголын ард түмний үндсээ «чөлөөлөх хөдөлгөөнд төдий л яльтай тусыг үзүүлж чаддаггүй»¹⁵ байв. Манж, хятадын колончлогчдын мөлжлөгийг зоригтой эсэргүүцэж байсан сайн эрсийн тоонд нийт монгол даяар нэр алдар нь цуурайтсан Дорнод Монголын Дарьгангын хошууны Торойбанди зүй ёсоор ордог. Торойбанди сайн эр, муу хулгай гэсэн хоёр цолтой бөгөөд сайн эр гэдэг нь ард түмэн өгсөн цол, муу хулгай гэдэг нь дотоод гадаадын эзэрхэгчүүдийн оноосон цол байв. Тэр мөн Торойбанди, Нанзад хэмээх хоёр нэртэй явжээ.

1860-аад оны дунд үеэр амьдарч явсан Нанзад буюу Торойбанди бол тэр үеийн монголын бэлэг авьяастай хүмүүсийн нэг байв. Ийм хүмүүс тухайн нийгмийн хавчлагаас болж цагаачин, бадарчин, сайн эр болж хувирах нь цөөнгүй байжээ. Торойбанди одоогоос 150 гаруй жилийн өмнө 1830-аад онд Манжийн хааны Дарьганга дахь хонин сүргийн нутаг буюу одоогийн Сүхбаатар аймгийн Онгон суманд нэгэн ядуу айлын хүү болон төржээ. Түүнийг багад нь Бургасан дугана хэмээх хийдэд шавилан суулгасан боловч дарлал мөлжлөгийг үзэн ядах тул шашны хоосон номд төөрч суухыг хүссэнгүй сүм хийдийг орхи-

жээ. Тэр үеийн хар, шар феодалууд, хятадын шунахай худалдаачид, мөнгө хүүлэгчдийн дарлал, мөлжлөг хэтэрхий байсан тул 20-иод наснаасаа чөлөөтэй амьдрахыг хүсч, аглаг газрыг эрэн Шилийн богд, Хорго уул зэрэг хоёр хөлтний ховор очдог газар дарлагч нараас хол нутаглах болжээ.¹⁶ Торойбанди ингэж явахдаа баяд ноёдын мал адуунаас хөөж, хятадын зальхай худалдаачдын эд хөрөнгийг булаан авч ядуу ардуудад түгээн өгөх зэргээр тэмцлээ явуулж байв. Торойбанди энэ бүхнийг хийхдээ зөвхөн амин хувийн эрх ашгийн төлөө биш, үгээгүй ардын амь зуулгыг хангах, тэдний тусын тулд халуун амь, бүлээн цусыг үл хайрлан зүтгэж явсан юм. Торойбанди энэхүү тэмцлээ Цэнд, Шархалзан Жамбал¹⁷ Ажив, Ширмэн хоовон, алия Содов,¹⁸ Дондог зэрэг хүмүүстэй хамтран хийж байжээ. Манжийн төрийн шахалт хятад худалдаачид, мөнгө хүүлэгчдийн гомдол, зарга, ноёд баядын хилэн хорслоос болж Торойбандийг баривчлахаар хэд хэдэн хошууны түшмэл цэргийг дайчлан Ар, Өвөр Монголоор зар тарааж байв. Торойбанди нэг биш удаа баригдаж шоронд орж байсан боловч ард олны тусламжаар шоронг эвдэн гарч байжээ. Түүнийг хүрээний шорон, Долоннуурын шорон зэрэгт сууж¹⁹ байсан гэж судалгааны зарим зохиолд тэмдэглэсэн байдаг. Торойбанди өнгөрсөн зууны сүүлээр хошуу нутагтаа эргэн ирэх амар тайвнаар аж төрж байгаад 1904 онд буюу хөх луу жил далан хэдэн насандаа Сүхбаатар аймгийн Онгон сумын «Хажуу» хэмээх газар нас баржээ. Торойбандийн тухай ардын дуу, доог арвин их байдаг.

Сайн эрсийн тухай ардын домог ихэвчлэн гадаад дотоодын давхар дарлалыг эсэргүүцсэн түүхэн үйл явдалтай холбогдон гарсан байдаг. Энд нэгэн түүхэн баримтыг өгүүлбэл, засаг Дуламжавын хошуунд Тон Вау гэдэг данжаад суурьшиж суудаг байжээ. Тэр данжаад дэлгүүр олонтой, мал ихтэй байжээ. 1863 оны 4-р сарын орчим Тон Вау данжаадын адуун сүрэг Заан ширээ гэдэг газар бэлчиж явахад Торойбанди хэмээх Нанзад нарын долоон «сайн эр» давхин очоод дөчин гурван адууг тасдан хөөж, ядуучуудад тараан өгсөн ба мөн данжаадын 500 гаруй тэмээ ачааг Ар хүрмийн тохой дэрс гэдэг газар булаан авч байсан гэдэг. Энэ мэт түүхэн явдалтай холбогдон гарч яваандаа уран сайхны хэтрүүлэг, олон түмний хүсэл мөрөөдлийг тусган ардын домог болсон зүйл арвин бий. Торойбандийн тухай «Зальхай худалдаачид мэс залгив», «Алтан овоон дахь байлдаан», «Өршөөсөн биш ширвээдсэн юм, «Гайхлууд танихгүй давхиж л явна» гэх мэт түүхэн үнэнтэй холбогдон гарсан олон домог байдаг. Үүнээс гадна «цагаан морь буг болдог», «Жанчхүүгийн замд», «Сэвхүүлийн Төмөр», «Хусран даагны хэрэг», «Хатуу цагийн ширүүн эрс», «Дарьсүрэнгийн тухай домог» зэрэг домгийн олон хувилбарт хятад худалдаачид, мөнгө хүүлэгчид, манжийн амбан нарын эсрэг эрс тэмцэл явуулж байсан сайн эрсийн тухай гарах бөгөөд тэмцэгч сайн эрс нь бяр чадал ихтэй, цөс зориг хатуу, уран нарийн арга, ухаан сайтай хүмүүс болон дүрслэгдсэн байдаг нь уг домгууд түүхэн үнэнд тулгуурласан уран сайхны хэтрүүлэг бүхий жинхэнэ ард түмний хүсэл мөрөөдлийн биелэл, баатрууд нь тэдний бие төлөөлөгчид болж байсныг харуулж байна. «Цагаан морь буг болдог» хэмээх ардын домогт хятадын шунахай худалдаачид монголын ард түмнийг шулан мөлжиж, өнгөтэй өөдтэй бүрийг авч байсныг эсэр-

¹⁶ Ц. Дамдинсүрэн. Торойбанди. «Үнэн» 1944—IX—15. № 217

¹⁷ Г. Жамсранжав. Торойбанди. «Цог» сэтгүүл. 1957. № 5. 79-р тал

¹⁸ Ц. Дамдинсүрэн Торойбанди «Үнэн» 1944—9. 15

¹⁹ П. Хорлоо. Монгол ардын явган үлгэр. УБ. 1960. 97-р тал

²⁰ «Цог» сэтгүүл. 1957 он. № 5. 79-р тал

гүүцэн тэмцсэн тухай өгүүлдэг. Нутаг орондоо цуутай сайн цагаан морийг нэг хятад худалдаачин авч нутаг буцаж явахад нь нэг сайн эр түүнийг буцаан авахаар шийдэж шөнө дагаж яваад морины хазаарыг мултлан хүзүүндээ углаад, чармаа нүцэглэн нэлээд дагасны эцэст уллан зогсож татаад явахгүй болсонд нөгөө зүүрмэглэж явсан данжаад эргэж харвал чармаа нүцгэн хүн зогсож байсанд ухаанаа гартал айж «сартай шөнийн цагаан морь чармаа нүцгэн буг болдог ваа» гэж орилоод зугтсан гэдэг. Үүнээс хойш хятад худалдаачид монгол нутгаас цагаан морь худалдан авахаа байсан гэж домогт өгүүлдэг. Монголчууд манжийн төрийн колоничлох бодлого, хятад худалдаачид мөнгө хүүлэгчдийн эдийн засгийн талаар эрхшээл нөлөөндөө оруулах оролдлогыг ингэж элдэв хэлбэрээр эсэргүүцэж иржээ. Түүнчлэн хятадын худалдаачид мөнгө хүүлэгчид монгол газрын байгалийн баялагт шунаж байсан тухай ардын домог их байдаг. Ард түмний дунд яригддаг «Алтан уулын домог», «Вангийн цагаан уул» зэрэгт энэ тухай тодорхой өгүүлсэн байдаг.

Дорнод аймгийн Халх гол сумын нутагт байдаг Вангийн Цагаан уул манжийн түшмэл «манай нутаг» хэмээн маргаан үүсгэхэд халхын Го зан:—Танай, манай хоёр айл буухад хүрвэл манай нохой идүүртэй хоолноосоо танай нохойд долоолгохгүй байх шүү гэж хэлээд «манай энэ уул ганцхан үхрийн ширний хэмжээтэй юм» гэсэнд манжийн түшмэл ихэд олзуурхан Вангийн цагаан уулыг манайх боллоо гэж боддог. Гэтэл То ван үхрийн шир зүсч нутгийнхаа уулыг хэмжихэд зүссэн шир нь илүү гарсанд энэ уулын алт булсан хэсгийг та нар хулгайлсан байна. Түүнийг өг! хэмээн түшмэлийг айлган хөөсөн гэж домогт өгүүлдэг. Энэ нь манай нутаг ус руу хятадууд хэзээнээс нааш өнгөлзөн санаархаж байсны баримт болохоор барахгүй монгол хүн хэн боловч төрсөн эх нутгаа харийн түрэмгийллээс хамгаалж ирснийг XIX зууны эхний үеийн Цэцэн хан аймгийн нэгэн хошууны ноён байсан То ван хэмээх түүхт хүнээр гаргасан нь бодит байдлыг улам ч үнэмшилтэй болгож байна. Монголын байгалийн баялаг алтанд шунаж ирсэн хятадууд Өмнөговь аймгийн Гурван тэс сумын нутагт байдаг Алтан уулын алтыг ухаж байгаад ховдог шунахай зангаасаа болж сүйрсэн тухай «Алтан уулын домогт» өгүүлжээ. Алт мөнгөний төлөө, баяжихын төлөө хувийн ашиг завшаан хөөцөлдсөн хятад худалдаачид, мөнгө хүүлэгчид ард түмнээс ямагт хөндий тасархай байж тэднийг зөвхөн хэрхэн хуурч аргалах, явал яс чөмгөнд нь хүртэл мөлжих тухай л «өдрийн бодол шөнийн зүүд» болж байсан тул монголчуудын дунд туйлын нэр хүндгүй, оршин байх байр сууриар ч тун тааруу байжээ. Хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчдийн зан чанарын талаар монголчууд бүү хэл гадаадын жуулчид хүртэл зохиол бүтээлдээ тэмдэглэсэн байдаг. «Бид шөнийн нэг цагт босч хоёр цаг болоход Тост уулын чиглэлд хөндий туулан гарах замдаа ороод явж байв... Өглөөний 7 цаг гэхэд бид 23 км явж Хөтөлийн худагт хүрлээ. Энд хятад худалдаачид суудаг ажээ... Хятадууд угийнхаа өөдгүй заншлаар бидэнд төдий л найртай хүндэтгэж хандсангүй...»²¹ гэж Орос-зөвлөлтийн нэрт эрдэмтэн П. К. Козлов 1923—1926 онд Монгол нутгаар аялсан тэмдэглэлдээ бичсэн байдаг. П. К. Козлов «хятадууд угийнхаа өөдгүй заншлаар» гэж онцлон тэмдэглэсэн нь монголыг шулан мөлжиж, улс төр, эдийн засгийн хувьд дангаар ноёрхох их санаа үргэлж агуулж байсан хятадын төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх зорилготой худалдаачид мөнгө

²¹ П. К. Козлов. Путешествие по Монголии. 1923—1926 гг (Дневники подготование к печати Е. В. Козловой) 1949 г. стр 176

хүүлэгчдийн цаад санааг олон жилийнхээ ажиглалтын явцад танин мэдэж нэлээд үндэстэй дүгнэсэн нь сонин бөгөөд бас ч үнэ цэнэтэй баримт болон үлджээ.

Манж болоод хятадын төрөөс монголчуудын эсрэг явуулж ирсэн харгис бодлогыг илчилсэн «Хүйсийн говь» хэмээх ардын нэгэн домог байдаг. Харийн түрэмгийлэл, цэрэглэсэн уулгаллын эсрэг монгол хүн бүр эх орон, газар шорооныхоо төлөө гэсэн тэмцэл явуулж байсан үед «Хятад газраас хар санаа өвөрлөж ирсэн хятад түшмэлийг нутгийнхаа шороон дээр бүү гишгүүл!» гэсэн зар бичгийг дамжуулан тараасан харуул өртөөний ядуу монгол айлд хятад цэрэг уулгалан ирж төрсөн хүүгээр нь эцэг эхийг нь алуулж, дараагаар нь өөрийн нь толгойг авч бүрэн бүтэн айл гэргийн голомтыг баллаж хүйс тэмтэрсэн тэр газрыг «Хүйсийн говь» (одоогийн Говь-Алтай аймгийн Хөхморь сумын нутагт байгаа) хэмээн нэрлэх болсон тухай ардын домогт өгүүлдэг.

Манжийн төрөөс монголын хувьд явуулж байсан бодлого зөвхөн ард түмний эрс эсэргүүцэлтэй тулгараад зогсохгүй мөн эх оронч үзэлтэй феодал ангийн дургүйцлийг ч хүргэдэг байв. Ийм жишээнд Чин Ван Ханддоржийн хүүгийн тухай домог зүй ёсоор орно. 1904 онд Төвдийн далай лам Монголд ирж монголын феодалуудтай нууцаар уулзаж, манж хятадаас хэрхэн тусгаарлах тухай асуудал хэлэлцэж байсан гэх тэр үед Далай лам буцахдаа Чин ван Ханддоржийн хүүг дагуулан явжээ. Далай лам замдаа манжийн хаанд бараалхах болж тусгай зассан шатаар явахад нь Ханддоржийн хүү хойноос нь дагаж цуг гартал манжийнхан далимдуулан хүүг барьж авч шоронд хориод Ханддоржийг очихоор нь цонхоор нь халт харуулаад толгойг нь авч Чин ван Ханддоржид барьсан гэдэг.²² Ийм явдлаас болж манж, хятадын төрийн бодлогыг эсэргүүцэх үзэл санаа монголын феодалуудын дотор ч ихсэж байсан жишээ бий.

Монголын ард түмний дунд тархсан ардын домгийг нарийвчлан судалвал монголын түүхтэй холбоотой нэлээд сонин үйл явдлуудын ул мөрийг өөртөө шингээсэн байдгийг мэдэж болно. Сүүлийн 300 гаруй жилийн түүхтэй холбоотой монгол ардын домгийн агуулга нь голдуу эх орны эрх чөлөө, тусгаар тогтнол, ард түмний жаргалант амьдралын төлөө эцсээ хүртэл тэмцэж явсан ардын баатруудын үйл явдалтай холбогдсон байхын зэрэгцээ харийн түрэмгийлэгчдийн эсрэг нийт монголын ард түмэн цэцэн оюун, хурц ухаан, уран аргаар хэрхэн тэмцэж явсан тухай өгүүлсэн түүх, аман зохиолын чухал ач холбогдолтой материал цөөнгүй байдаг. Тухайлбал монголын ард түмний дунд ихэд дэлгэрсэн «жигүүртний хаан Хангарьд», «Эр зоригийн таван омог», «Хар хүрээтэй малгай» зэрэг олон домгийг нэрлэж болно. Манжийн колончлогчид монголд тогтоосон ноёрхлоо улам бэхжүүлэхийн тулд монголын ард түмнийг улс төр, эдийн засгийн хувьд боолчлоод зогсохгүй, ёс суртахуун, бэлэг чанарын хувьд мохоон доройтуулахыг ямагт эрмэлзэж байсныг монголчууд шийдвэртэй эсэргүүцэн тэмцэж байсан тухай дээрх домгуудад тов тодорхой өгүүлсэн байдаг. «Жигүүртний хаан Хангарьд» хэмээх домогт манж нар монголын ард түмнийг эрхшээл нөлөөндөө байнга байлгахын тулд гал түлдэг тулгыг өөрчилсөн тухай гардаг. Тулгын 4 тотгын дээд талыг хэрээний хошуу дуурайлган хийж, «монголын гал голомтыг хэрээ тоншиж, монголчууд дэлхийн хөрснөөс үнс мэт хийсэн арилтугай» гэсэн утгатай болгожээ. Гэтэл монголчууд түүний эсрэг эхнэр хүний хувцас гэдгийг зохиосон гэдэг.

²² Энэ домгийг эрдэмтэн зохиолч Э. Оюун гуайн цуглуулгаас авч жишээ болгон орууллаа.

Эхнэр хүний хувцас нь жигүүртний хаан Хангарьдыг дуурайлгасан бөгөөд хэрэв хэрээ монголын гал голомтыг тоншвоос жигүүртний хаан Хангарьд би чамайг барин авч даруй тасдан хаяна гэсэн ёгт утгатай болжээ. Эмэгтэй хүн өрх гэрийн гал голомтыг бадрагч ариун үйлстэн тул ийнхүү түүнд эхнэр хүний хувцас зохион өмсүүлж манжийн төрийн колоничлох далд бодлогыг няцааж байжээ. Энэ бол тухайн үеийн үзэл суртлын томоохон тэмцэл юм. «Эр зоригийн таван омог» «Хар хүрээтэй малгай» зэрэг домогт манж, хятадын зүгээс монголчуудыг дарлан боолчлох гэсэн санааг манай ард түмэн цэцэн оюун хурц ухаанаар няцааж байсныг мөн нэг адил өгүүлсэн байдаг.

ПРЕДАНИЯ ВОСПРОИЗВОДЯТ ИСТОРИЮ

(Р е з ю м е)

Богатый фольклор монголов отражает многовековую историю монгольского общества, наиболее главные и важные события в жизни страны, описывает быт и трудовую деятельность простого народа. Среди обширной тематики народного творчества отдельно стоят легенды и предания, возникшие за последние 300 лет и посвященные борьбе монгольского народа против маньчжурских завоевателей. Этому вопросу, в частности, и посвящена данная статья.

В первую очередь следует отметить ярко выраженный воспитательный характер и патриотический настрой преданий и легенд, это отчетливо прослеживается на примере легенд об Амурсане и Чингунжаве. Поражение восстаний не смогло сломить освободительный дух народа, но было воспринято как временная неудача, после чего обязательно придет победа, которую одержат либо сами Амурсана и Чингунжав, либо их перерожденцы.

В преданиях и легендах того времени содержится множество ценных сведений о народных героях, в одиночку боровшихся против угнетателей простого народа. В преданиях такие люди наделяются всеми лучшими качествами, выдумкой и изобретательностью, что безусловно, не всегда соответствовало истине. Народ видел в них своих лучших представителей, ведущих борьбу за справедливость.

С проникновением в Монголию китайского ростовщического капитала, распространяются легенды о сопротивлении монголов китайским купцам и торгашам, целью которых было эксплуатировать простой народ и присвоить чужую землю. Примечательно, что в легендах на эту тему на стороне народа выступают и некоторые представители монгольской знати.

Несмотря на то, что в процессе перехода от поколения к поколению легенды и предания обрастают вымышленными эпизодами и сюжетными наслоениями, они, как правило, несут в себе достоверную информацию о главном событии, вокруг которого уже развиваются последующие действия. Подлинное событие, обогащенное мыслями и чаяниями простого народа, превращается в легенду одну из форм фиксации истории для последующих поколений. Именно поэтому изучение и анализ образцов фольклора должны занимать важное место не только в фольклористике, но и в исторической науке в целом.